



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Барилга байгууламжийг нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон болон худалдан авсан нийт 22,124,153,553.40 (хорин хоёр тэрбум нэг зуун хорин дөрвөн сая нэг зуун тавин гурван мянга таван зуун тавин гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
53 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	164 дүгээр цэцэрлэгийн Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө /100 ор/	Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, Ханбүргэдэй их дэлгүүрийн зүүн талд, 164 дүгээр цэцэрлэгийн хашаанд	2023.12.12		1,043,467,568.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
2	8 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж /240 ор/	Баянзүрх дүүргийн 16-р хороо, 16-р хороолол, Дандарбаатарын 1-р гудамж, Офицеруудын ордны зүүн хойно	2023.06.08		5,512,985,185.40	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө
3	318 дугаар цэцэрлэгийн барилга /240 ор/	Баянзүрх дүүргийн 13-р хороо, Алтан тэвшийн амины орон сууц гудамжинд	2018.11.24	2022.12.08	4,983,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
4	320 дугаар цэцэрлэгийн барилга /150 ор/	Баянзүрх дүүргийн 23-р хороо, Хужирбуланд, 87-р сургуулийн урд талд	2016.12.09	2023.06.16	2,073,600,000.00	
5	145 дугаар цэцэрлэгийн барилга /75 ор/	Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Вива сити 3/16 байр 1-1-4 тоот	2013.07.30	2022.12.20	572,700,000.00	
6	322 дугаар цэцэрлэгийн барилга /100 ор/	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс ажилчны гудамж 80/7 байр 2 тоот	2022.04.18	2023.02.28	1,676,000,000.00	
7	324 дүгээр цэцэрлэгийн барилга /150 ор/	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсан /17020/ Дүнжингарав гудамж 206/2 байр	2018.03.16	2023.02.09	2,862,400,800.00	
8	325 дугаар цэцэрлэгийн барилга /100 ор/	Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо, Стадион оргил, Их Монгол улсын гудамж, 100/7 тоот	2015.06.16	2022.12.05	3,400,000,000.00	
Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн					22,124,153,553.40	